Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 7 хоногийн мэдээ
/2019.08.05-2019.08.09/

2018.08.09 **Дархан хот**

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
		Барилга хот байгуулалтын хэлтэс
1	Барилгын чиглэл	- Дархан сумын Өргөө багт баригдах Геронтологийн төвийн барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон.
2	Инженерийн дэд бүтцийн чиглэл	- Дархан сумын 15-р багт баригдаж буй Од сургуулийн заалны өргөтгөлийн барилгын гадна шугам сүлжээний барилга, Дархан сумын 9-р багт баригдаж буй 9, 10-р багийн төвийн барилгын гадна дулааны шугамын барилгын ажлуудтай тус тус танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.
		Газрын удирдлагын хэлтэс
1	Инженер, хайгуул Мониторингийн чиглэл	- Жайка Олон улсын байгууллагын "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн баг Дархан-Уул аймагт 2019 оны 08 дүгээр сарын 07-ны өдөр аймгийн "Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулах 7 дахь удаагийн сургалтыг аймгийн Онцгой байдлын газрын гал унтраах 54-р ангид зохион байгуулагдсан, уг сургалтанд 2 албан хаагчийг хамрууллаа.
3	Газар зохион байгуулалт, өмчлөлийн чиглэл	- Дархан сумын 15-р багт тавигдаж буй авто замын зурвасд орсон 5 иргэнд 3 хоногийн хугацаатай шаардах хуудас хүргүүллээ. - Орхон, Хонгор, Шарын гол сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг дэлгэрэнгүй гарган 2019 оны 08 дугаар сарын 13 –ны дотор яаралтай ирүүлэх албан тоо хүргүүлсэн. - Аймгийн Прокурорын газрын хүсэлтийн дагуу нэг нэгж талбарын түүхчилсэн дэлгэрэнгүй лавлагааг хүргүүлсэн.
4	Газрын төлбөр, татвар, үнэлгээний чиглэл	- 2019.08.09-ний өдрийн байдлаар 409.3 сая төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 55 хувьтай байна. 46 иргэн, аж ахуй нэгж байгууллагад Төлбөрийн даалгавар үүсгэж ажилласан байна. “Сонголон хайрхан” ХХК-ний шүүх хурал 2019.08.19-ний өдрийг хүртэл хугацаагаар гуравдагч этгээдийн хүсэлтээр хойшлогдсон.
5	Кадастр	- Гэр бүлийн хэрэгцээний өмчлөх **12** иргэн, худалдсан, бэлэглэсэн **6,** эзэмших гэрээ байгуулсан **10** иргэн, хуулийн этгээдийн кадастрын зургийг тус тус гаргаж өгсөн. Мөн Орхон суманд Гэр бүлийн хэрэгцээний өмчлөх 1 иргэн, худалдсан, бэлэглэсэн **3,** Шарын гол суманд Гэр бүлийн хэрэгцээний өмчлөх 1 иргэний бүртгэлийг хийж кадастрын зургаар үйлчилсэн. - Хог хаягдлыг булшлах, ландфиллын болон хог хаягдал ангилах, нягтруулах цэг байгуулах газрын тойм зургийг 2019.08.07-ны өдөр Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлэв.

Захиргаа аж ахуй хэлтэс		
1	Мэдээлэл технологийн чиглэл	Хүний нөөц: - 2019.08.05–2019.08.06-ны өдрүүдэд жирэмсний болон амаржсаны амралтаа авч буй Дархан сумын даамал Ө.Мягмарсүрэнгийн ажлыг хүлээлцүүлэх комисс ажиллалаа. Нярав: - Кадастр, гэрчилгээний үнэт цаасны 7-р сарын зарцуулалтын тайланг гаргав. - Нэгж талбарын хувийн хэрэг 10 ширхэгийг нугалж бэлтгэв. - Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 100 ширхэг кадастрын цаас, 9 ширхэг НТХХ, 13 ширхэг газар эзэмших гэрчилгээ /иргэн/, 3 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ААНБ/ үнэт цаас олгов. - Шаардах хуудсаар 9 төрлийн 33 ширхэг бараа материал олгов. Мэдээлэл технологийн чиглэл: - Серверийн өрөө, өрөөний кондишныг цэвэрлэв. - 2019.07.30-2019.08.05-ны хоорондох цаг бүртгэлийн машин дахь мэдээллийг хурууны хээ унших машинаас Able систем рүү хөрвүүллээ. - Байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хуудсанд Дархан сумын дахин дуудлага худалдааны зарыг байрлуулав. - Аймгийн ЗДТГ-ын МТА-аас хөтөлдөг “Дархан-Уул аймаг” фэйсбүүк хуудсаар дамжуулан “Дархан сумын дахин дуудлага худалдаа”-ны зарыг байршуулав. - Байгууллагын цахим хуудсанд байгууллагын 2017, 2018, 2019 оны үйл ажиллагааны тайлангуудыг байрлуулах кодыг HTML хэл дээр бичиж, нөхөн байрлуулав. - 70376471 нээлттэй утсаар 7 иргэн, байгууллагын фэйсбүүк хуудсанд ирсэн 1 иргэний асуултын дагуу хариулт өгөв. Архив, бичиг хэрэг: - Газрын эрхийн хугацаа сунгасан, талбай өөрчлөгдсөн, эрх шилжүүлсэн, шинээр олгогдсон нийт 187 нэгж талбарын хувийн хэргийг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэн, архивт хүлээн авлаа. - Энэ долоо хоногт тус байгууллага нь 14 өргөдөл /119 хуудас/, 23 албан бичиг /148 хуудас/ хүлээн авч, 13 албан бичиг /17 хуудас/ явуулж, 5 тушаал /5 хуудас/ баталсан байна.

Тайлан нэгтгэсэн: Ц.Цэнд-Аюуш

Хянасан: Г.Нямдорж /ГУХ-ийн дарга/